

УАНС-гийн Бүс нутгийн Ногоон санхүүгийн систем – Монгол Улс – Хаан Банк

Байршил:	МОНГОЛ УЛС
Төслийн дугаар:	57140
Бизнесийн салбар:	Хадгаламжийн зээл (банкууд)
Мэдэгдлийн төрөл:	ХУВИЙН ХЭВШИЛ
Байгаль орчны ангилал:	
Батлагдсан огноо:	2026 оны 5 дугаар сарын 14
Төлөв байдал:	Судалж байгаа
Англи хэлээр нийтэлсэн огноо:	2026 оны 4 дүгээр сарын 8

Төслийн танилцуулга

Уур амьсгалын ногоон сангийн Ногоон санхүүгийн систем (“УАНС-гийн НСС-ийн зээл”)-ийн хүрээнд ХААН Банк ХК (“ХБ”, эсвэл “Компани”)-д олгох 80 сая хүртэлх ам.долларын анхдагч өглөгт тооцогдох, хөрөнгийн барьцаагүй зээл. Тус нийт дүнгээс 72 сая хүртэлх ам.долларын зээлийг ЕСБХБ-наас ам.доллар, эсвэл төгрөгөөр, 8 сая хүртэлх ам.долларын зээлийг Уур амьсгалын ногоон сан (“УАНС”)-гаас ам.доллароор тус тус олгоно. УАНС-гийн НСС-ийн зээлийг хоёр тэнцүү хэсэг (транш)-т хуваан олгох бөгөөд үүний хоёр дахь хэсгийг нь заавал олгох үүрэг хүлээхгүй.

Төслийн зорилго

УАНС-гийн НСС-ийн зээл нь санхүүжилтийн бааз сууриа төрөлжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг саармагжуулах болон түүнд дасан зохицох технологи, үйлчилгээнд жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалт хийх Монголын хувийн хэвшлийн үйлчлүүлэгчдэд дунд хугацааны санхүүжилт хийх боломжийг ХААН Банкинд олгох бөгөөд ингэснээрээ Эдийн засгийн ногоон шилжилт (“ЭЗНШ”) хийхэд хувь нэмэр оруулах юм.

Шилжилтийн нөлөөлөл

Хүлээгдэж буй шилжилтийн нөлөөлөл (ЕТI)-ийн оноо: 75

Тус төсөл нь УАНС-гийн НСС-ийн Бүсийн суурь хүрээний зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж, Шилжилтийн нөлөөллийн ногоон чанарыг дэмжин, зээлийн хөрөнгийг УАНС-гийн НСС-ийн Монгол Улсын талаар баримтлах бодлогын мэдэгдэлд нийцүүлэн 100 хувь ЭЗНШ-ийн үйл ажиллагаанд зориулах болно.

Үйлчлүүлэгчийн тухай мэдээлэл

ХААН БАНК ХК

ХБ нь Монголын хамгийн том арилжааны банк бөгөөд 2025 оны эцсийн байдлаар нийт 6,7 тэрбум ам.долларын хөрөнгөтэй (банкны салбарын нийт хөрөнгийн 28 хувь), зээлийн багц нь 3.8 тэрбум ам.доллар (33 хувь), өөрийн хөрөнгө нь 793 сая ам.доллар (33 хувь) болсон байна. Тус банк цахим банкны сувгууд болон орон даяар байршсан 529 салбар бүхий сүлжээгээр дамжуулан, нийт хүн амын 84 гаруй хувьд хүрч үйлчилж байна. Банк өнөөдрийн байдлаар Moody's агентлагаас "В1/тогтвортой", Fitch агентлагаас "В+/тогтвортой" үнэлгээ аваад байгаа бөгөөд энэ нь засгийн газрын үнэлгээтэй нэг түвшинд очсон гэсэн үг юм.

ЕСБХБ-ны санхүүжилтийн тойм

72,000,000.00 ам.доллар

Ам.доллар, эсвэл төгрөгөөр олгох 72 сая хүртэлх ам.долларын анхдагч өглөгийн зээл.

Төслийн нийт өртөг

80,000,000.00 ам.доллар

80 сая ам.доллар, үүнээс 72 сая хүртэлх ам.долларыг нь ЕСБХБ-наас ам.доллар, эсвэл төгрөгөөр олгох, 8 сая хүртэлх ам.долларыг нь УАНС-гаас олгох.

Нэмэлт ашиг тус

Дунд хугацааны хөрөнгө оруулалтыг техник тусламжийн үйл ажиллагаа, түүний дотор санхүүжилтийн шинэлэг бүтэц, хэрэгслүүдтэй хослуулах, мөн нүүрсхүчлийн ялгаруулалт багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй эдийн засагтад шилжихэд тус дөхөм үзүүлэхүйц илүү өндөр түвшний стандартад хүрэхэд нь туслах замаар стандарт тогтоох боломж олгоно.

ХБ-ны бизнес эрхлэлтийн стандартыг сайжруулах, эмэгтэй болон эрэгтэй дэд зээлдэгчдэд хандсан, ногоон санхүүжилтийн талаарх мэдлэг, мэдээлэл олгох кампанит ажил явуулах, эмэгтэй дэд зээлдэгчдэд зориулсан санхүүгийн суурь мэдлэг олгох сургалт (ногоон санхүүд төвлөрсөн) зохион байгуулах зэрэг арга замаар бизнес үйл ажиллагаандаа жөндөрийн асуудлыг тусган, жөндөрийн хувьд олж авах нэмэлт ашиг тусыг бий болгоно.

Байгаль орчин, нийгмийн тойм

“Санхүүгийн байгууллага” ангилал (2024 оны Байгаль орчин, нийгмийн бодлого). Байнгын үйлчлүүлэгч болох ХБ-ыг одоогийн байр сууринаас нь авч үзвэл байгаль орчин, нийгмийн сайн гүйцэтгэлтэй ажиллаж байгаагаа харуулсан болно. Зээлийн орлогыг шаардлага хангасан бөгөөд эмэгтэйчүүд болон залуучууд толгойлсон БЖДҮ-ийн газруудад дамжуулан зээлдүүлэх УАНС-ийн

НСС-ийн Монголд зориулсан Бүсийн хөтөлбөрт ашиглах бөгөөд эдгээр хоёр төрлийн БЖДҮГ нь БОН-ийн үүднээс бага болон дунд түвшний эрсдэлтэй гэж тооцогдож байна.

ХБ-ны Байгаль орчин, нийгмийн менежментийн систем нь ЕСБХБ-ны стандартад нийцсэн байдаг бөгөөд зээлийн нийт багц дээр ашиглагддаг байна. ХБ 2010 оноос уур амьсгалын өөрчлөлт, хүний эрх, хүүхдийн эрх, биологийн олон янз байдал зэргийг хамарсан Тогтворой хөгжлийн бодлого хэрэгжүүлэн, өөрийн өдөр дутмын үйл ажиллагаандаа нэгтгэн тусгаж ирсэн. Мөн ханган нийлүүлэгчдийнхээ гүйцэтгэлд тогтвортой байдал, нийгмийн хариуцлагын шалгуурууд дээр тулгуурлан тогтмол үнэлгээ хийж байна. Дээр нь, ХБ Тогтворой хөгжлийн болоод БОНЗ-ын жил дутмын тайлангаа вэбсайт дээрээ байршуулсан байдаг. Тус Банк 2010 оноос НҮБ-ын Даян дэлхийн гэрээний гишүүн болж, 2023 онд Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэлд нэгдэж орсон.

ХБ нь дэд төслүүдтэй холбоотой БОН-ийн эрсдэл, нөлөөлөлд үр дүнтэй үнэлгээ, менежмент, мониторинг хийхэд БОН-ийн менежментийн системээ бэлэн байлгах, ЕСБХБ-ны 2024 оны БОН-ийн бодлогын БОНШ 2, 4 ба 9, түүний дотор Үл зөвшөөрөх жагсаалт болон Хяналтын жагсаалтыг үргэлжлүүлэн дагаж мөрдөх, ЕСБХБ-ны БОН-ийн эрсдлийн удирдлагын холбогдох удирдамжид нийцүүлэн ажиллах, БОН-ийн жил дутмын тайлангаа ЕСБХБ-нд хүргүүлж байх шаардлагатай. ХБ-ны зээлээр санхүүжиж байгаа дэд зээлдэгчид байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөрийн асуудлаарх үндэсний хууль тогтоомжуудыг сахин мөрдөж байх ёстой.

Ногоон үнэлгээ

Шууд бус санхүүжүүлэлттэй хөрөнгө оруулалтыг Парисын хэлэлцээрт нийцүүлэх ЕСБХБ-ны арга хандлагыг хэрэглэн авч үзсэний үндсэн дээр тус төсөл нь Парисын хэлэлцээрт нийцэж байна гэж тодорхойлж байна. Ийнхүү нийцэж байгааг тодорхойлохдоо Багана 1 (хамтрагч нөгөө тал Парисын хэлэлцээрийн хүрээнд үүрэг амлалт авсан байдал) болон багана 2 (дэд транзакцийн шүүлтүүр)-ыг ашигласан болно.

Уур амьсгалын өөрчлөлтийг саармагжуулах, түүнд дасан зохицох зорилгуудад хүрэх үйл ажиллагааг дэмжиж байгаа учир ЕСБХБ-ны санхүүжилтийг 100 хувь ногоон санхүү гэж ангилж байна. Ингэж ангилахдаа ЕСБХБ-ны хөрөнгө оруулалтын ногоон санхүүгийн мөн чанарыг тодорхойлох аргачлалын дагуу гүйцэтгэсэн болно.

Техник хамтын ажиллагаа ба Буцалтгүй тусламжийн санхүүжилт

А. Техник хамтын ажиллагаа ("ТХА").

УАНС-ийн НСС-ийн зээлийг улс орны суурь хүрээний түвшинд ТХА-ны багц тусламжаар дэмжиж ажиллах бөгөөд түүний зарим хэсгийг ЕСБХБ-ны Хувь нийлүүлэгчдийн тусгай сан ("ХНТС")-гаас гаргаж, үлдсэн хэсгийг дараагийн үе шатанд босгож авах юм.

ТХА-ны зорилго нь УАНС-гийн НСС-ийн зээлийг ашиглахдаа жендэрийн мэдрэмжтэй арга замаар чадавхи бий болгох, хэрэгжилт хангах, мониторинг хийхэд нь ХБ-нд туслалцаа үзүүлэх явдал юм. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь арилжааны үйл ажиллагаанд ашиглах уур амьсгалын өөрчлөлтийг саармагжуулах болон түүнд дасан зохицох технологийн ноу-хауг дамжуулах, түүний тухай мэдлэгийг нэмэгдүүлэх, төслийн үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх, дэд зээлдэгчдийг хамгийн оптимал технологи сонгож авахад нь чиглүүлэх зэрэг ажил гүйцэтгэнэ. Жендэрийн асуудлаарх эксперт нь ТХА-ны гүйцэтгэлийн бүхий л асуудалд

жендэрийн холбогдолтой үйл ажиллагаа (жишээ нь, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, маркетинг, сурталчлан таниулах ажиллагаа)-г нэгтгэх ажилд туслалцаа үзүүлнэ..

Үйлчлүүлэгчийн хувь нэмэр: ХБ нь төслийн хэрэгжилттэй холбогдох маркетинг, сургалтын зардалд зэрэгцээ хувь нэмэр оруулна.

БЖДҮ-ийн газруудад үзүүлэх ТХА-ны тусламж нь ногоон практик, технологи нэвтрүүлэх, түүний дотор сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх, нөөц хэмнэх арга хэмжээ авах, тогтвортой ногоон хөдөө аж ахуйн практик ашиглахад нь, мөн түүний хажуугаар ногоон санхүүг шингээх чадвараа сайжруулахад нь ХБ-ны боломжит дэд зээлдэгчдэд туслах санхүүгийн бус зорилтот үйлчилгээ үзүүлэх замаар хэрэгжинэ. Европын Холбооны *КОВИД-19-ийн дараах Монгол Улсад хямралд тэсвэртэй ЖДҮ бий болгох төсөл* (АСА/2021/420-670)-өөс санхүүжилт гаргах нь баталгаажсан болно.

В. Хамтын хөрөнгө оруулалтын буцалтгүй тусламж/Хөнгөлөлттэй санхүүжилт ("ТХА-ны бус")

УАНС-гийн НСС-ийн зээлийг УАНС-гаас гаргах ТХА-ны бус буцалтгүй тусламжийн хөрөнгөөр болон 3 хүртэлх хувийн Үр дүнд суурилсан нөхөн олговор ("ҮДСНО")-ын хэлбэрээр олгох санхүүгийн урамшууллын буцалтгүй тусламжаар дэмжиж ажиллана. ҮДСНО нь уур амьсгалын шилжилтийн төлөвлөгөө, холбогдох шилжилтийн стратеги боловсруулан хэрэгжүүлэх, эцэст нь уур амьсгалын шилжилтийн төлөвлөгөөнийхөө суурь элементүүдийг олон нийтэд танилцуулахад нь ХБ-нд урам зориг өгнө гэж тооцоолж байна.

Компанитай холбоо барих мэдээлэл

Ариунжаргал Чулуунбаатар, Олон улсын банкинг газрын захирал

investmentbank@khanbank.com

+976 99070819

www.khanbank.com

ХААН Банк ХК, ХААН Банк Тауэр, Чингис Хаан өргөн чөлөө-6, Цэнгэлдэх Оргил-1, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар 17010 Монгол Улс

ТХББ-ийг хамгийн сүүлд шинэчилсэн

2026 оны 4-р сарын 8

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг [эндээс](#) авна уу.

Бизнес боломжууд

Бизнес боломжууд болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авалттай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл [ЕСБХБ-ны Худалдан авалт](#) хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

[БОНБ](#) болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д үйлчлүүлэгчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх, мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа үйлчлүүлэгч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн, тухайн төслийн улмаас үүсэх эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх нэмэлт шаардлагыг үйлчлүүлэгчиддээ тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг [БОНБ](#)-д оруулсан болно.

Бүрэн төгс байдал ба комплаенс

ЕСБХБ-ны Комплаенс хариуцсан Захирлын Ажлын алба (КЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг практикт нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаан дахь бүрэн төгс байдлыг хамгийн дээд стандартаар хангахад анхаарч ажилладаг. Төслүүдийн зүгээс Банкинд бүрэн төгс байдал, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд тус Банк бүх үйлчлүүлэгчийнхээ бүрэн төгс байдалд нарийвчилсан үнэлгээ хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны транзакцийн бүрэн төгс байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. КЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, мөн төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах бүрэн төгс байдлын эрсдлийг хянахад тус дөхөм үзүүлдэг.

Түүнчлэн, КЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга,

хээл хахууль болон буруу үйлдлийн талаарх гомдлын мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд, эсвэл гадна байгаа хэн ч бай залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй тохиолдолд Комплаенс хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаяг руу бичгээр илтгэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг КЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүх мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алинаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь чин сэтгэлийн байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны вэб сайтаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#) хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо үйлчлүүлэгч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: үйлчлүүлэгчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн [Байгаль орчин, нийгмийн бодлого](#), эсвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#)-ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний эрх үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл [Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб сайт](#), хянан шалгуулах хүсэлт тавих бол [Хүсэлт](#) хаягаар тус тус хандана уу. Эсвэл ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол ipam@ebrd.com цахим шуудангаар хандаж болно.